



**Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын
төлөвлөгөө, удирдамжийн дагуу хийсэн
нийцлийн аудитын тайлан**

**“ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ЗЭЭЛИЙН
ХУВААРИЛАЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**



**Сангийн сонгон шалгаруулалт зохих журмын дагуу явагдаагүй
байна.**

Агуулга

Тайланг бэлтгэсэн:
Говь-Алтай аймаг
дахь Төрийн
аудитын газар

Дарга, Тэргүүлэх
аудитор
Х.Түвшинбаяр
Утас: 99489309

Аудитын менежер
Д.Эрдэнэчимэг
Утас: 99175677

Аудитор
Ц.Сайханжаргал
Утас: 88665099

2018 оны 9 дүгээр
сар

Аудитын тайлан,
дүгнэлттэй
холбоотой асуудлаар
нэмж тодруулах,
асууж лавлах зүйл
байвал 70483413,
70484055 дугаарын
утсаар харилцана уу.

Товчилсон үгсийн жагсаалт.....	2
Аудит хийх үндэслэл, зорилт, хамрах хүрээ, арга зүй...	3
Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт.....	4
Үндсэн мэдээлэл.....	5

Нэг: Төсөл сонгон шалгаруулахдаа холбогдох журмын шаардлагыг харгалзаж үзээгүй байна.

1.1 Сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу явуулаагүй байна.

1.2 Сонгон шалгаруулалтад оролцсон нийт иргэн, аж ахуйн нэгжийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлсэн эсэхийг нотлох боломжгүй байна.

Хоёр: Тус сангаас 2015 оноос хойш төсөл хөтөлбөрт зээл олгоогүй байна.

2.1. Зээлдэгч нар нь хуваарийн дагуу зээлийг хугацаанд нь эргэн төлж байна.

2.2. Төсөл сонгон шалгаруулах дэд комисс нь сонгон шалгаруулалт хийхдээ бусад эх үүсвэрээс зээлтэй эсэхэд ач холбогдол өгдөггүй байна.

2.3. Зээлдэгч нар нь зээлийг зориулалтын дагуу зарцуулж байна.

2.4. Олон нийтэд мэдээлэл дутмаг байна.

Гурав: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хяналт шалгалтыг хийсэн гэх боловч нотлох баримтгүй байна.

3.1 Харьяалах дээд шатны байгууллагаас жил бүр хяналт шалгалт хийсэн гэх боловч нотлох баримтгүй байна.

3.2 Хяналтаар илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг орон нутгийн холбогдох албан тушаалтанд мэдээлдэггүй байна.

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГАА	Говь-Алтай аймаг
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НА	Нийцлийн аудит
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани
СХС	Сум хөгжүүлэх сан

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулалт явуулсан эсэх
- Сангийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа эсэх
- Хяналт хангалттай, үр нөлөөтэй ажиллаж байгаа эсэх

Аудитын хамрах хүрээ

Аудитаар тус сангийн 2013 оноос хойших зээл олгох сонгон шалгаруулалт, хуваарилалт, хэрэгжилт, хяналтын үйл ажиллагааг хамруулан шалгалаа.

Үндсэн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, зорилго

Тус сан нь Монгол улс дахь ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, ажлын байрыг шинээр бий болгох, хадгалах зорилгоор Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөрүүд, Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл, Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрүүдийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад мөнгөн хөрөнгийн зээл олгох, тоног төхөөрөмжийн лизингийн үйлчилгээ үзүүлэх, давхар батлан даалт гаргах зэрэг хуулиар зөвшөөрөгдсөн дэмжлэгүүдийг үзүүлэх үндсэн чиг үүрэгтэй.

Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг төвлөрүүлэн хөнгөлөлттэй нөхцөл бүхий зээл олгож, тэднийг дэмжих замаар эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэхэд оршино. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зориулж хөнгөлөлттэй зээл олгох;
2. Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн туршлагыг харилцан солилцуулах;

3. Төрөөс дэмжлэг авч үйл ажиллагаагаа өргөжүүлсэн, ажлын байр бий болгосон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах, үзэсгэлэн худалдаанд хамруулах;

Аудитын стандартын талаарх мэдэгдэл

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгоно.

- Төрийн аудитын тухай хууль
- Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль /2007/
- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль /2006 он/
- Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоол.
- Хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын 2017 оны А-76 дугаар тушаал.
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт стандарт.

Аудит ашигласан арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, Нийцлийн аудитын удирдамж 4000-4100 дугаар стандартууд болон Нийцлийн аудитын түр журмыг баримтлан тус сангийн албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, сангийн худалдан авалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа санхүүгийн тайлан бусад шаардлагатай материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх бөгөөд аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, нотлох зүйлийг цуглуулж аудитын үр дүнд үндэслэн дүгнэлт гаргаж нийтэд мэдээлэхэд оршино.

Үндсэн мэдээлэл:

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2009 оны 1 тоот тушаалаар “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам”-ны **“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”** нэртэйгээр үүсгэн байгуулагдсан бөгөөд түүнээс хойш хэд хэдэн яамны харьяалалд чиг үүргийн дагуу шилжсэн боловч өнөөдөр ууган яамныхаа харьяанд буюу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нэрийн дор үйл ажиллагаагаа явуулж байна. Манай аймгийн хувьд 2013 онд 500.0 сая, 2014 онд 1000.0 сая, 2015 онд 300.0 сая төгрөгийн эх үүсвэр хуваарилагдаж ирсэн бөгөөд 1193.5 сая төгрөгийн гэрээ байгуулан санхүүжилт олгожээ. Сонгон шалгаруулалтад оролцон банкны шалгуур үзүүлэлт хангаагүйн улмаас зээл 606.5 сая төгрөгийн сан буцаан татсан байна. 2016-2017 онд санхүүжилт хуваарилагдаж ирээгүй байгаа бөгөөд сонгон шалгаруулалт, зээл олголт хийгдээгүй байна.

Нэг. Төсөл сонгон шалгаруулахдаа холбогдох журмын шаардлагыг харгалзаж үзээгүй байна.**1.1 Сонгон шалгаруулалтыг зохих журмын дагуу явуулаагүй байна.**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын 09-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулах дэд комиссыг аймгийн Засаг даргаар ахлуулан 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж аймгийн Засаг даргын 2013 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/113 дугаар захирамжаар тус дэд комиссын ажиллах журмыг батлан мөрдөж байжээ.

Төсөл сонгон шалгаруулах дэд комиссыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 50 дугаар тогтоолоор 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр, Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 04 сарын 22-ны өдрийн 79 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр дахин шинэчлэн байгуулсан байна.

Уг төсөл сонгон шалгаруулах комисс нь 2013 онд 1 удаа, 2014 онд 2 удаа, 2015 онд 2 удаагийн хуралдаан давхардсан тоогоор 179 иргэний төсөлд сонгон шалгаруулалт явуулж 94 төслийг дэмжин холбогдох банкуудад судлуулахаар хүргүүлжээ.

Аудитад хамрагдсан баримтын хүрээнд авч үзэхэд Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/49 дугаар тушаал¹, Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 40 дүгээр тушаал², 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 64 дүгээр тушаал³-аар батлагдсан журамд заасан нийт шаардлагыг хангасан эсэхийг харгалзан үзэхгүйгээр бүрдэл хангалтгүй төслийг орон нутгийн хэрэгцээ шаардлагыг үндэслэн олонхын саналаар шийдвэрлэсэн байна. /Хавсралт №1/

1.2 Сонгон шалгаруулалтад оролцсон нийт иргэн, аж ахуйн нэгжийн жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлсэн эсэхийг нотлох боломжгүй байна.

Аудитад хамрагдсан баримтыг хүрээнд сонгон шалгаруулалтын баримт материалыг авч үзэхэд шалгаруулалтад оролцсон нийт иргэн, аж ахуйн нэгжийг

¹ Жижиг дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журмын хавсралт “Хөнгөлөлттэй зээл олгоход тавих шаардлага”

² Жижиг, дунд үйлдвэрийн салбарын орон нутгийн чанартай төсөлд тавигдах шалгуур үзүүлэлтийн жагсаалт

³ Төслийн иж бүрдэл

жижиг дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Мөн тус сангаас зээл авсан 29 зээлдэгчийн хувийн хэрэгтэй танилцахад 18 иргэн нь “жижиг, дунд үйлдвэр эрхлэгч” иргэн гэрчилгээтэй, харин бусад 11 зээлдэгч аж ахуйн нэгжийн нэрээр зээл авсан бөгөөд журамд заасны дагуу жижиг, дунд үйлдвэр эрхлэгчээр бүртгүүлсэн эсэхийг нотлох баримтыг хавсаргаагүй байна.⁴ /Хавсралт №2/

Тодруулга: Сонгон шалгаруулалтад тэнцээгүй иргэдийн төслийн материалыг буцаан олгодгоос шалтгаалан хариуцсан албан тушаалтанд бүх материал байхгүй байсан бөгөөд аудитад хамрагдсан хурлын тэмдэглэл, гишүүдийн үнэлгээ өгсөн хуудас, сонгон шалгаруулалтад тэнцсэн зээлдэгчийн хувийн хэрэгт үндэслэн дүгнэлтийг өгсөн болно.

Хоёр. Тус сангаас 2015 оноос хойш төсөл хөтөлбөрт зээл олгоогүй байна.

2.1. Зээлдэгч нар нь хуваарийн дагуу зээлийг хугацаанд нь эргэн төлж байна.

Зээлийн үйл ажиллагааг орон нутагт салбар нэгжтэй, тусгай шалгуур үзүүлэлт хангасан банктэй холбогдох яам болон Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан хамтран ажиллах гэрээ байгуулан явуулж байна. Манай аймгийн хувьд 2013 оноос хойш Хаан, Хас, Төрийн, Капитал банкнуудаар дамжуулан 29 төсөл хөтөлбөрт 1,073,500.0 мянган төгрөгийн зээл олгосон бөгөөд 2018 оны 09 дүгээр сарын байдлаар 17 зээлдэгч 173,131.7 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна.⁵ Зээлийн эргэн төлөлтийн эрсдэлийг хамтран ажиллах гэрээний дагуу банкнууд хүлээж байна.⁶ Банк нь төсөл сонгон шалгаруулах дэд

⁴ Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/49 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 1.4-т “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиглэлээр олгох хөнгөлөлттэй зээлд хамрагдах аж ахуйн нэгж, иргэн Жижиг дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан шалгуур үзүүлэлтийг хангаж, 6 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлсэн байна.”

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А-76 тоот тушаалын 1 хавсралт “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 1.1-т “Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5.2, 14.6 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтыг үндэслэн экспортыг нэмэгдүүлж, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжин, гарааны бизнес эхлүүлэх болон ажлын байр бий болгож нэмэгдүүлэх зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн төсөл сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.”

⁵ Хүнс, хөдөө аж ахуйн газраас ирүүлсэн судалгаанаас.

⁶ Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/49 дугаар тушаалын 2 дугаар хавсралт “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 3.1.2-т “Зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа

комиссоос ирүүлсэн төслийг өөрийн чиг үүргийн хүрээнд судлан шийдвэрлэж зээл олгох гэрээ байгуулан эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлдэгч зээлийн буцаан төлөлт хийж байна.

***Тодруулга:** Банкууд нь Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сантай хамтран ажиллах гэрээний дагуу зээлийн эргэн төлөлт, түүнээс үүсэх эрсдлийг хүлээж байгаа бөгөөд санд ямар нэгэн хохирол учрахгүй тул зээлийн буцаан төлөлтийн байдлыг /санхүүгийн асуудал/ аудитад чухалчлан үзээгүй болно.*

2.2. Төсөл сонгон шалгаруулах дэд комисс нь сонгон шалгаруулалт хийхдээ бусад эх үүсвэрээс зээлтэй эсэхэд ач холбогдол өгдөггүй байна.

Төсөл сонгон шалгаруулах дэд комисс нь төслийг хүлээн авч шалгаруулалт хийхдээ журамд заасны дагуу зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл, татвар, нийгмийн даатгалын хэлтсийн өр төлбөртэй эсэх тодорхойлолтыг үзэж байгаа боловч улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс зээлтэй, зээлийн өр төлбөртэй эсэх асуудлыг харгалзан үздэггүй байна.⁷ Үүнээс үүдэлтэйгээр зээлдэгч нь 1 төслөөр хэд хэдэн санхүүжилт авах, давхар зээлтэйн улмаас зээлийг хугацаанд нь буцаан төлж чадахгүй болох зэрэг эрсдэлийг дагуулж байна. Тухайлбал: Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас зээл авсан 29 зээлдэгчийн мэдээллийг 2011 оноос 2017 оны 12 сарын 31-ний өдрийн хооронд сумдын “Сум хөгжүүлэх сан”-аас зээл авсан 1561 зээлдэгч⁸, 2014-2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй төсөл

эрсдэлийг Сангийн өмнө бүрэн хариуцахаа илэрхийлсэн баталгаа гаргаж нотариатаар баталгаажуулсан байх”

Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 64 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт “Төсөл сонгон шалгаруулах хороо болон дэд хорооны журам”-ын 5.5-д “Хяналт, шинжилгээ, үнэлгээний явцад илэрсэн зөрчил, дутагдлыг ... тухайн өдрөөс эхлэн уг зээлийг дамжуулан олгосон банкны арилжааны зээл рүү шилжүүлэн Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх санд банкны эх үүсвэрээс бүрэн дүнгээр буцаан төвлөрүүлнэ. Энэхүү хариуцлагын талаар банктай хамтран ажиллах гэрээгээр нарийвчлан тодорхойлж өгнө”.

⁷ Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/44 дүгээр тушаалын “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журмын хавсралт “Хөнгөлөлттэй зээл олгоход тавих шаардлагын А.2-г “Татварын болон зээлийн хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх”

Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 64 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт “Төслийн иж бүрдэл”-ийн 7.7-д “Хэвийн зээлийн өрийн үлдэгдэлтэй бол тус зээлтэй холбоотой баримт /зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга, тодорхойлолт, зээлийн зарцуулалтын тооцоо/”

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А-76 тоот тушаалын 1 хавсралт “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 4.8.7-д “зээлийн өрийн хэвийн үлдэгдэлтэй бол уг зээлтэй холбоотой баримт /зээлийн гэрээ, зээлийн дансны хуулга, тодорхойлолт, зээлийн зарцуулалтын тооцоо гэх мэт/”

⁸ Сум хөгжүүлэх сангийн зээлдэгчийн мэдээллийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн статистик мэдээнд үндэслэв.

хөтөлбөр, хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 684 иргэн, хуулийн этгээд⁹ -ийн мэдээлэлтэй тулган давхар зээл авсан эсэхэд хяналт хийж үзэхэд:

- “Сүүт сүрэг” төслөөр 2015 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зээл авсан Бигэр сумын иргэн Х.Ерөөлт нь тус сумын Сум хөгжүүлэх сангаас 2013 оны 04 дүгээр сарын 10-нд “Бөөний болон жижиглэн худалдаа” төслөөр 10,000.0 мянган төгрөгийн зээл
- “Цэвэр ус” төслөөр 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр зээл авсан Дэлгэр сумын Гуулийн тосгоны иргэн Г.Хатанболд нь тус сумын Сум хөгжүүлэх сангаас 2013 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр “Цэвэр ус” төслөөр 20,000.0 мянган төгрөгийн зээл
- “Сүлжмэл эдлэл” төслөөр 2015 оны 07 дугаар сарын 29-ны өдөр зээл авсан Есөнбулаг сумын иргэн Г.Байгальмаа нь тус сумын Сум хөгжүүлэх сангаас 2013 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр “Сүлжмэл эдлэл” төслөөр 10,000.0 мянган төгрөгийн зээл тус тус авсан байна. /Хавсралт №3/

Гэтэл Х.Ерөөлт нь 337.0 мянган төгрөг, Г.Хатанболд /Гуулин шим ХХК/ нь 837.69 мянган төгрөг, Г.Байгальмаа нь 277.6 мянган төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар СХС-ийн зээлийн төлөөгүй үлдэгдэл буюу манай байгууллагаас тогтоосон төлбөрийн актын үлдэгдэлтэй байна.

Харин Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас давхардуулан төсөл хөтөлбөрт хамрагдаагүй бөгөөд Есөнбулаг сумын иргэн Г.Байгальмаа нь 2017 онд Ажлын байр дэмжих хөтөлбөрийн хүрээнд “ажлын байрны түрээсийн хөнгөлөлт”-д хамрагдсан байна.

2.3. Зээлдэгч нар нь зээлийг зориулалтын дагуу зарцуулж байна.

Өнөөдрийн байдлаар зээл авсан байгаа 29 төсөл хөтөлбөрөөс Есөнбулаг сум болон ойролцоо сум, тосгонд үйл ажиллагаа явуулж буй 16 төслийг түүвэрчлэн авч бодит байдалтай танилцахад 2 төсөл үйл ажиллагаа явуулаагүй байна. Үүнд:

1. Есөнбулаг сумын иргэн Д.Батмөнхийн “Авто машин техникийн зах байгуулах” төсөл: Хуучнаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын баруун талд блокон хашаа босгон худалдааны үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон боловч бизнес эрхлэгч иргэн, аж ахуй нэгжүүд байршаагүй, одоогийн үйл ажиллагаа явуулж буй захаас нүүлгэн шилжүүлэлт хийгдээгүй байна.

⁹ “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан”-ийн үйл ажиллагаанд Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны 06 дугаар сард хийсэн нийцлийн аудитын материалд үндэслэв.



2. Дэлгэр сумын Гуулин тосгоны иргэн Г.Хатанболдын “Цэлмүүн цэвэр ус” төсөл: Үйл ажиллагаа явуулан 1 торх цэвэр усыг 5.0 мянган төгрөгөөр борлуулж байсан боловч “Гэгээн нуур цэвэр ус” ОНӨААТҮГ нь шинээр байгуулагдан 1 торх цэвэр усыг олон нийтэд 0.5 мянган төгрөгөөр борлуулж эхэлснээр худалдан авагчгүй болж 2016 оноос үйл ажиллагаа бүрэн зогссон байна.



Харин бусад зээлдэгч нарын хувьд тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уулзалт хийх, утсаар ярилцахад үйл ажиллагаа өргөжсөн, төслийн дагуу үйл ажиллагаа явуулан ашигтай ажиллаж байгаа тухай мэдээллийг өгч байлаа.

Тус сангаас зээл авсан 29 зээлдэгчийн аймгийн татварын албанд төлсөн татвар төлөлтийн байдлыг 2015 оноос 2017 оны хооронд авч үзэхэд 2015 онд 14 зээлдэгч 2,496.0 мянган төгрөг, 2016 онд 11 зээлдэгч 1,618.1 мянган төгрөг, 2017 онд 9 зээлдэгч 2,725.8 мянган төгрөг, нийт 6,840.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогын татварын орон нутагт төлсөн байна. Үүнээс үзвэл аудитаар уг 29 зээлдэгчийн 27 нь үйл ажиллагаа явуулж байхад 13 зээлдэгч нь огт татвар төлөхгүй байгаа нь төсөл хөтөлбөрийн үр дүн орон нутгийн төсөвт үр өгөөжгүй байгааг харуулж байна.

Мөн уг сангаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд нь ажлын байрыг хадгалах, шинээр бий болгоход чиглэх боловч аймгийн Нийгмийн даатгалын хэлтсээс ирүүлсэн судалгаагаар Сангаас зээл авсан 29 иргэн, аж ахуйн нэгжээс 9 буюу 31 хувь нь нийгмийн даатгалын шимтгэл төлсөн байна. Оноор авч үзвэл 2015 онд 20, 2016 онд 18, 2017 онд 17 иргэн шимтгэл төлсөн байгаа нь тус сангийн зорилтыг бүрэн хангахгүй байна.¹⁰ Зээл авсан иргэдийн хувьд сайн дураараа шимтгэл төлдөггүй, харин аж ахуйн нэгжүүдийн хувьд албан журмын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу 1-4 иргэн шимтгэл төлж байгаа нь хяналт шалгалт сул байгааг харуулж байна.

2.4. Олон нийтэд мэдээлэл дутмаг байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан” гэсэн шилэн дансны цахим хуудсанд мэдээллээ байршуулж байна. Харин Шилэн дансны “Говь-Алтай аймаг”¹¹ болон “аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар”¹² -ын цэс, өөрийн цахим хуудсанд ямар нэгэн хэлбэрээр мэдээлэл байршуулаагүй бөгөөд орон нутгийн иргэдэд мэдээлэл дутмаг байна.

Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны А-76 дугаар тушаалаар “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 5 дугаар зүйлийн

¹⁰ Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/44 дүгээр тушаалын “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 1.2-т “...энэ зээл нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээ шинээр эрхлэх, өргөтгөх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.”

Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 64 дүгээр тушаалын 1-р хавсралтын 1.2-т “...ажлын байр бий болгоход зарцуулна.”

Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн А-76 тоот тушаалын 1 хавсралт “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох төсөл сонгон шалгаруулах журам”-ын 1.1-т “...ажлын байр бий болгож, нэмэгдүүлэх...”

¹¹ <http://shilendans.gov.mn/org/38>

¹² <http://shilendans.gov.mn/org/1262>

5.8-д “Сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг Шилэн дансны тухай хуулийн 3.2.3¹³-д заасан дагуу нийтэд ил тод мэдээлнэ” гэж заасан тул цаашид сонгон шалгаруулалт явуулах тохиолдолд шилэн дансны цахим хуудсанд мэдээлж ажиллах хэрэгтэй байна.

Мөн 2014, 2015 онд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг, шторк бэлтгэн зээлийн үйл ажиллагаа үр дүнг олон нийтэд мэдээлсэн байна.

[illegible]

Гурав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харъяа Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хяналт шалгалтыг хийсэн гэх боловч нотлох баримтгүй байна.

3.1 Харъяалах дээд шатны байгууллагаас жил бүр хяналт шалгалт хийсэн гэх боловч нотлох баримтгүй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас жил бүр аймагт олгогдсон хөнгөлөлттэй зээлийн үйл ажиллагаатай танилцан зээлийн зориулалт, зарцуулалтад хяналт шалгалт хийсэн гэх боловч орон нутагт хяналт шалгалтын тайлан, илэрсэн зөрчлийн талаарх баримт материалаа танилцуулаагүй байна. Хяналт шалгалт хийсэн эсэхийг нотлох баримтгүй, зөвхөн аймгийн ХХААГ-ын мэргэжилтэн С.Нинжбадамын тайлан байна.

3.2 Хяналтаар илэрсэн зөрчлийн талаарх мэдээллийг орон нутгийн холбогдох албан тушаалтанд мэдээлдэггүй байна.

ЖДҮДС-аас хяналт шалгалт хийсэн ажлын тайлан, мэдээллээ аймгийн холбогдох албан тушаалтанд өгдөггүй, албан бичгээр баталгаажуулан хүргүүлдэггүй тул хяналт шалгалтаар ямар зөрчил илэрсэн, ямар шийдвэр өгөгдсөн нь тодорхойгүй байна.

¹³ 3.2.3.Засгийн газрын тусгай сан;

Аудитаар хяналтын үр дүнг давтан тооцоолох боломжгүй байгаа тул цаашид уг асуудлыг хариуцсан албан тушаалтан анхаарах шаардлагатай гэж үзлээ.¹⁴

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Дэд комисс нь төсөл сонгон шалгаруулахдаа холбогдох журамд заасан шаардлагыг хангасан, төслийн бүрдэл бүрэн эсэхийг тодруулахгүйгээр сонгон шалгаруулалтыг хийсэн байна.
2. Зээлдэгч нь улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөс зээлтэй, зээлийн өр төлбөртэй эсэх асуудлыг харгалзан үздэггүй байна.
3. Есөнбулаг сумын иргэн Д.Батмөнхийн “Авто машин техникийн зах байгуулах” төсөл, Дэлгэр сумын Гуулин тосгоны иргэн Г.Хатанболдын “Цэлмүүн цэвэр ус” төсөл нь үйл ажиллагаа явуулаагүй, үр дүнгүй байна.
4. Зээлдэгчийн татвар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт хангалтгүй байна.
5. Хяналт хийсэн ажлын хэсгээс илэрсэн зөрчлийн талаар холбогдох албан тушаалтанд мэдээлэл өгөөгүйгээс дээд шатны байгууллагаас хийсэн шалгалт үр дүнгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга С.Гансэлэмд:

1. Цаашид төсөл сонгон шалгаруулахдаа холбогдох журмын шаардлагыг бүрэн хангасан жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зээл олгож байх.
2. Төсвийг үр ашигтай, орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн улс, орон нутгийн төсвөөс зээл авсан зээлдэгчид зээл давхардуулан олгохгүй байх.
3. Сангаас зорилтыг хангуулах, зээл авсан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг төлүүлэх ажлыг зохион байгуулах.

¹⁴ Хөдөлмөрийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 19-ны өдрийн А/44 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын 7.1. Хяналт шинжилгээ үнэлгээг жилд 2-оос доошгүй хийж, тайланг тухай бүр танилцуулан үр дүнг тооцож ажиллана.

7.3. Сан нь комиссын зээлийн тайланг гарган, улсын хэмжээнд олгогдсон хөнгөлөлттэй зээлийн мэдээ, тайланг нэгтгэж холбогдох удирдлага, газар, нэгж, олон нийтийг мэдээллээр хангана.

Аж үйлдвэрийн сайдын 2015 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 64 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 5.6. “...хяналт-шинжилгээ, үнэлгээг жилд 1-ээс доошгүй удаа хийж тайланг тухай бүр танилцуулж үр дүнг тооцон ажиллана.”

Холбогдох байгууллагын санал**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

82091 Харзат баг, Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг

Утас: 7048-4004, Факс: (976)7048-3360

2018.10.07 № 1/2224
танай 2018.10.07 -ны № 210 -т**АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАРТ**

Танай газраас ирүүлсэн “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зарцуулалт, төсвийн хэрэгжилт”-д нийцлийн аудит хийсэн зөвлөмж дүгнэлттэй танилцлаа. Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.



С.ГАНСЭЛЭМ

Д.Удвалогшилт
Төрийн хөдөлгөөн
Баталгаатсуулж
хурлуулж.

2018.10.05